



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 09

Мандалговь

Д.Отгонзулыг Мэргэжлийн хяналтын газрын  
Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын  
улсын байцаагчийн албан тушаалд  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Доржпаламын Отгонзул 53.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Д.Отгонзулын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь  
салбар зөвлөлийн 2022 оны ...08... дугаар сарын  
08...-ны өдрийн ...09... дугаар тогтоолын хавсралт



**Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын  
хяналтын улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн  
Д.Отгонзулын тухай дүгнэлт**

1. Д.Отгонзул нь 1994 онд Дундговь аймгийн Дэрэн суманд төрсөн. 28 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2012-2017 онд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийг хүний их эмч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2017-2018 онд Говь-Угтаал сумын сум дундын эмнэлэгт нийгмийн эрүүл мэндийн ажилтан, 2018 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгт тархвар судлаач эмчээр ажиллаж байсан.
4. Д.Отгонзулын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ